ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 04 өдөр

Дугаар 120/2025

Улаанбаатар-16100
Утас: 70001150
Факс: 70007636

Объектын нэр:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто зам, 16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто замын зураг, төсөв
Объектын байршил:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
Хүчин чадал:	0.182 км, 0190 км, 0.334 км, 0.687 км, 0.818 км, 0.083 км
Захиалагч:	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	"Ихэр мөнх" ХХК
Регистрийн дугаар:	5914337
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2030.03.25
<u>Зураг төсөл боловсруулах үндэслэл:</u>	
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	-
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто замын зургийн даалгавар, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто замын зургийн даалгавар, Нийслэлийн ерөнхий архитекторын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдөр баталсан авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар, № 2024/00-428, Нийслэлийн ерөнхий архитекторын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр баталсан авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар, № 2024/00-141,
Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон "Ихэр мөнх" ХХК-ийн хооронд 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Зам, замын байгууламжийн зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ, Багц-2, /ХУДХААА/202412037/, № ХО/110, Зураг төсөл боловсруулах гэрээний үнэ: 89 693 380 төгрөг,

<u>Техникийн нөхцөл:</u>

Техникийн нөхцөл	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
Инженерийн байгууламж	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	№ 01/04334/24 2024.09.16	2 жил
Инженерийн байгууламж	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	№ 01/04335/24 2024.09.16	2 жил

<u>Зөвшилцсөн байгууллага:</u>

Нийслэлийн ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр

162509046

Хот байгуулалт, хотын стандартын газрын Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ц.Лхамсүрэн
Хот байгуулалт, хотын стандартын газрын Замын хөдөлгөөн, төлөвлөлт хариуцсан инженер	Б.Дулмаа
Нийслэлийн замын хөгжлийн газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	М.Ичинхорлоо
Нийслэлийн замын хөгжлийн газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн	Х.Ганбат
Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	З.Буянт
Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Мөнхбаатар
"Геодези, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер	С.Батсайхан
"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер	Т.Мөнхболд
Хот байгуулалт, хотын стандартын газрын Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн	Б.Оргил
Нийслэлийн онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Хошууч	Б.Даваасүрэн

<u>Зураг төслийн бүрэлдэхүүн:</u>

Зургийн бүрдэл:	Зураг төслийг гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:
Авто замын зураг	"Ихэр мөнх" ХХК	Ч.Баясгалан
Тайлбар бичиг		
Техникийн шаардлага		
Авто замын төсөв		Б.Минжбадам
Геодезийн тайлан	"Эй Эс системс" ХХК	-
Инженер-геологийн тайлан /Барилгын хөгжлийн төвөөр 2024.09.12-ны өдөр магадлал хийсэн байна/	"Лэнд тест" ХХК Архив № 24/363, 24/364	-
Гэрэлтүүлгийн зураг	"Хайтал мегават" ХХК	Ж.Амарсанаа
Гэрэлтүүлгийн төсөв		Б.Октябрь

<u>Ерөнхий дүгнэлт:</u>

Авто зам, замын байгууламжийн чигийн сонголт болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт:	**Авто зам, замын байгууламжийн төлөвлөлт, хучин чадал:** **Авто замын ангилал:** Нутаг дэвсгэрийн гудамж зам, <u>13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто зам</u> Төрөл 1: Зорчих хэсгийн өргөн 6.0м, явган хүний замын өргөн 1х1.5м, хөвөөний өргөн 2х0.5м байхаар төлөвлөсөн байна. Төрөл 2: Зорчих хэсгийн өргөн 6.0м, явган хүний замын өргөн 2х1.5м, хөвөөний өргөн 2х0.5м байхаар төлөвлөсөн байна. <u>16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто зам</u> Зорчих хэсгийн өргөн 6.0м, L хэлбэрийн авто замын хашлаганы өргөн 2х0.5м, явган хүний замын өргөн 2х1.5м, хөвөөний өргөн 2х0.5м байхаар төлөвлөсөн байна. **Авто замын хучилтын хийц:** <u>13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто зам</u> Өнгө асфальтбетон хучилт 30 мм Суурь асфальтбетон хучил 40 мм Буталсан чулуун суурь 200 мм Хөлдөлтөөс хамгаалах үе 300 мм <u>16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто зам</u> Байгалийн чулуун хучилт 100 мм Элс цементэн багсармал 30 мм Буталсан чулуун суурь 200 мм Хөлдөлтөөс хамгаалах үе 300 мм **Явган хүний замын хучилтын хийц:** <u>13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто зам</u> Асфальтбетон хучилт 50 мм Буталсан чулуун суурь 150 мм <u>16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто зам</u> Явган хүний замын өнгөт хавтан 60 мм Элс хайрган суурь 150 мм

	Авто замын гэрэлтүүлэг: 13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто зам Алсын удирдлагатай гэрэлтүүлгийн удирдлагын самбар 1 ком, нэг толгойтой 9 м-н өндөр гэрэлтүүлгийн шон 56ш, 120вт-ын гэрлийн толгой 56ш, 0.4кв-ын 5*25кв.мм хөндлөн огтлолтой хөнгөн цагаан голтой кабель 1885м, 0.4-10кв-ын ЦДКШ, ЦДАШ зөөхөөр төлөвлөсөн байна. 16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто зам Алсын удирдлагатай гэрэлтүүлгийн удирдлагын самбар 1 ком, нэг толгойтой 9 м-н өндөр гэрэлтүүлгийн шон 32ш, 120вт-ын гэрлийн толгой 32ш, 0.4кв-ын 5*25кв.мм хөндлөн огтлолтой хөнгөн цагаан голтой кабель 929м, 0.4-10кв-ын ЦДАШ зөөхөөр төлөвлөсөн байна.
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:	Орон тооны бус экспертийн дүгнэлтийн дагуу зураг төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж дахин хянуулан баталгаажуулсан байна. Үүнд: Зурагт: Авто замын зурагт /2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн дүгнэлт/ Гэрэлтүүлгийн зурагт /2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дүгнэлт, 12 дугаар сарын 19-ний өдрийн дүгнэлт/ Төсөвт: Авто замын төсөвт /2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн дүгнэлт/ Гэрэлтүүлгийн зурагт /2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дүгнэлт, 12 дугаар сарын 24-ний өдрийн дүгнэлт/ Дээрх дүгнэлтүүд нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт болно.
Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:	Зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах норм, дүрмүүдийг баримтлан боловсруулсан байна. Үүнд: -ЗЗБНбД 22-004 -2016 "Авто зам төсөллөх" -БНбД 30-01-04 "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" -БНбД 32-01-06 "Хот суурины гудамж, зам төлөвлөлт" -БНбД 32-02-12 "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" -ЗЗБНбД 83-25-2023 "Авто замын барилгын төсвийн жишиг норм" -ЗЗБНбД 83-28-2023 "Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм" -ЗЗБНбД 83-26-2023 "Авто замын засвар арчлалтын төсвийн жишиг норм" -ЗЗБНбД 81-013-2019 "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" -АЗУАГН 2.01.01-2004 "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" -MNS 6808:2019 "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" -MNS 4596:2014 "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" -MNS 4980:2014 "Авто замын гэрлэн дохио. Техникийн ерөнхий шаардлага" -MNS 4759:2014 "Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага" -MNS 4597:2014 "Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" -БНбД 81-95-12*/2020 "Барилгын төсөв зохиох дүрэм" -БД 43-101-03 "Цахилгаан байгууламжийн дүрэм" -БД 43-101-03*/12 "Цахилгаан байгууламжийн дүрэм" -БНбД 23-02-08 "Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг"
Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт	Төсвийг орон тооны бус экспертүүд дараах байдлаар хянаж баталгаажуулсан байна. 13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто замын барилгын ажлын төсөв **2 515 140 351** төгрөг, 16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто замын барилгын ажлын төсөв **2 811 348 760** төгрөг,

	13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто замын гэрэлтүүлэг, 0.4-10кв-ын ЦДАШ зөөх ажлын төсөв **412 103 281** төгрөг, 16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто замын гэрэлтүүлэг, 0.4-10кв-ын ЦДАШ зөөх ажлын төсөв **212 541 141** төгрөг, Төсвийн нийт тооцоо, иж бүрдлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үнэ бүрдлийн норм, нормативын дагуу тооцсон болохыг хянав.

"Авто замын тухай" хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь заалтад заасны дагуу Авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч хариуцах ба зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн тооцооны талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцна.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто зам, 16 дугаар хороо, Буянт-Ухаа 6 дугаар гудамжны авто замын зураг, төсвийн баримт бичгийг холбогдох нормуудын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн бөгөөд уг зураг төслөөр замын ажил гүйцэтгэх боломжтой гэж дүгнэж байна.

Тус зураг, төсвийн баримт бичигт "Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын дагуу магадлалын ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь орон тооны бус экспертүүдийн гаргасан дүгнэлтийн хамт хүчинтэй. (Хавсралт: 17 хуудас)

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ — Д.ОЮУНБОЛД

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Э.БАЛТ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — Э.ЭНХТӨГС

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

- Ажлын зураг (Зургийн шифр 24/23) 62 хуудас А3
- Тайлбар бичиг (Зургийн шифр 24/23) 39 хуудас А4
- Техникийн шаардлага (Зургийн шифр 24/23) 194 хуудас А4
- Инженер геодезийн тайлан 29 хуудас А4
- Инженер геологийн судалгааны дүгнэлт 15 хуудас А4, 4 хуудас А3

д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,16-р хороо, Буянт-Ухаа 6-р гудамжны авто замын зураг төсөл
2	Обьектын байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, ХАн-Уул дүүрэг,16-р хорооны нутаг дэвсгэрт Авто замын урт 0.82 км, +0.083 км
3	Зураг төслийн байгууллага	"Ихэр мөнх" ХХК
4	Зургийн инженер	Б.Түвшинтөгс
5	Захиалагч	Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн ЗДТГ
3.Дүгнэлтийн товч утга.		
/Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалын 9 дүгээр зүйлээс/		Дүгнэсэн нь:
1	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	1. Ажлын даалгавар • Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгийн газрын дарга С.Энхбаярын 2024 оны 6 сарын 6-ний өдөр баталсан "Хан-Уул дүүргийн 16-р хороо, Буянт-Ухаа 6-р гудамжны авто замын зургийн даалгавар". Зургийн даалгавар дугааргүй. • Нийслэлийн ерөнхий архитектор Г.Батзоригийн 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдөр баталсан 2024/00-141 дугаартай "Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар" 2. Авто замын байршил, техникийн нөхцлийн талаар дараах байгууллагатай зөвшилцсөн байна. • Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Буянт, • Нийслэлийн замын хөгжлийн газрын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга В.Мягмар • Нийслэлийн замын хөгжлийн газрын бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн И.Номингэрэл • Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мөнхбаатар, • Геодези, усны барилга байгууламжийн ерөнхий инженер С.Батсайхан 3. Авто замын байршил, техникийн шийдлийг баталсан байдал • Нийслэлийн ерөнхий архитектор Ч.Төгсгэрэл баталсан. • Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандарын газрын Ерөнхий архитекторын ажлын алба 2025 оны 2 дугаар сарын 24-ний өдөр тэмдэг дарж баталгаажуулсан. Ингэхдээ ХБХСГ-ын 2024 оны 2024/00-141 дугаартай авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврын дагуу гүйцэтгэсэн" гэж тэмдэглэсэн. •

		• Хот байгуулалт, хотын стандартын газрын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч Ц.Лхамсүрэн, инженер Б.Дулмаа нар хянасан байна.
2	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	• Нарийвчилсан зураг төслийн эхний 2 хуудас буюу Дүүргийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн гарын үсэгтэй хуудас, Нийслэлийн замын хөгжлийн газрын хэлтсийн даргын гарын үсэгтэй хуудсууд дээрхи алдаатай тоон үзүүлэлтүүдыг гараар зассаныг засварлах. Хуудсыг засварлаж дахин хэвлэж гарын үсгийг зуруулах. • Орц, гарцны нэг маягийн хөндлөн огтлолийн зураг гэсэн зурагт авто замын 1-р трассын нэг маягийн хөндлөн огтлолийн зургийг хуулж тавьсан нь зургийн инженерийн хэнэггүй, хариуцлагагүй ажил болжээ. • Нэг маягийн хөндлөн огтлол болон Захиалагчтай зөвшилцсөн хуудас, тайлбар бичигт явган хүний замыг өнгөт хавтангаар төлөвлөж зурсан атлаа "Ажлын тоо хэмжээ"-д асфальт бетоноор зурж, дэвсэгчээр дэвсэхээр тооцсон нь ойлгомжгүй • Нийт замын трасс нь цэвэр, бохир усны шугамтай давхцсан учир Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас анхааруулж Ус сувгийн удирдах газартай зөвшилцөхийг зөвлөсөн боловч зөвшилцсөн материал байхгүй байна. • Замын трассын дагуу налуугийн хамгийн их налуу 106 промиль байгаа нь "Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам"-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 8%-иас их байгаа нь төлөвлөлтийн нормыг зөрчсөн байна. • Трасс-2-ийн авто замыг нэг зурвастай, 3 м-ийн өргөнтэйгөөр төлөвлөсөн нь "Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам"-ын "зурвасын эгнээний тоо 2, нэг зурвасын өргөн 3.0м" гэсэн заалтыг зөрчиж байна. • Авто замын зорчих хэсгийн өргөнийг "Нэг маягийн хөндлөн" огтлолд "L" хашлагийг оролцуулан тооцсон нь төлөвлөлтийн алдаа гэж үзэж байна. • Хашлага хэвтүүлж гаргах гарцыг 8 м-ийн өргөнтэйгөөр М250 цементбетоноор хийхээр зурсан боловч зургийн нүүр зурганд байгалын чулуун хучилт гэж зурсан нь ойлгомжгүй байна. Цемент бетоны ажлын тоо хэмжээг тооцоогүй байна. • Инженер геодезийн хэмжилтийн ажлыг "Эй Эс системс" ХХК гүйцэтгэж зураглалын тайлан ирүүлсэн байна. Инженер. Г.Золбаяр. Зөвлөх инженер Ш.Ганболд • Инженер геологийн судалгааны ажлыг "Лэнд тест" ХХК гүйцэтгэж дүгнэлт ирүүлсэн. Инженер Д.Баяржаргал, Мэргэшсэн инженер А.Оргилболд
3	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	• Инженер геодезийн зураглалын тайлангийн "Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэрэг №1, №2, №3" нь гарын үсэг зурагдаагүй, баталгаагүй. • Инженер геологийн судалгааны дүгнэлт Улсын магадлалаар 2024 оны 9 сарын 12-д баталгаажсан.
4	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	• Зам барилгын ажлын ерөнхий техникийн шаардлага, зураг төслийн тайлбар бичигт тусгасан. •
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/	

1	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	•
2	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	•
3	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	•
4	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам төлөвлөсөн. •
5	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, норматив баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	• Засвартай хуудсуудын дахин хэвлэж гарын үсгийг зуруулах. • Орц, гарцны нэг маягийн хөндлөн огтлолийн зургыг өөрчлөн дахин зурах • Явган хүний замын ажлын тоо хэмжээг өнгөт хавтангаар тооцож “Ажлын тоо хэмжээ”-д тусгах • Трасс-1-ийн хамгийн их дагуу налууг норм, стандартад заагдсанаар дахин төлөвлөх. • Трасс-2-ийн авто замыг “Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам”-ын “зурвасын эгнээний тоо 2, нэг зурвасын өргөн 3.0м” гэсэн заалтын дагуу төлөвлөх • Нэг маягийн хөндлөн огтлолийг дахин зурах • Хашлага хэвтүүлж гарц гаргах зургийг дахин шинээр зурах • Ус сувгийн удирдах газар болон цахилгаан, холбоо, дулааны холбогдох мэргэжлийн байгууллагуудаас техникийн нөхцөл авах, хэрэв авах шаардлагагүй бол тэр тухайгаа тайлбар бичигт тодорхой тусгах • Инженер геодезийн зураглалын тайлангийн “Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэрэг №1, №2, №3”-д гарын үсэг зуруулж баталгаажуулах • Нарийвчилсан зургийн булангийн хүснэгтэд бичигдэх хуудасны дугаарыг дахин хянаж, засварлах
Зөвлөмж: Дээрх шүүмжийн дагуу засварлан, дахин хянауулах.		

Дүгнэлт бичсэн:

ЭКСПЕРТ № ЧОЙЖИЛЖАВ овогтой БАЯСГАЛАН .....

(гарын үсэг)

2025 оны 04 дугаар сарын 04-ний өдөр

MONGOLIA ЗЗИ-22/005 CONSULTING ENGINEER BAYASGALAN Choijiljav

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2
ЭКСПЕРТИЗИЙН ДҮГНЭЛТИЙН ХАРИУ

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 16 ДУГААР ХОРОО,БУЯНТ-УХАА 6-Р ГУДАМЖНЫ АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

2025 оны 5 сарын 07-ны өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын байршил, хүчин чадал	Хан-Уул дүүрэг 16-р хороо 0.902м
2	Объектын нэр, шифр	Хан-Уул дүүргийн 16-р хороо Буянт-Ухаа 6-р гудамжны авто замын зураг төсөл Шифр:24/23
3	Зураг төслийн байгууллага	"Ихэр мөнх" ХХК
д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Засвартай хуудсыг дахин хэвлэж гарын үсэг зуруулах.	Засвартай хуудсыг засаж дахин хэвлэж хүргүүлэв.
2	Орц гарцын нэг маягийн хөндлөн огтлол зургийг дахин өөрчилж зурах	Орц гарцын нэг маягийн хөндлөн огтлолыг өөрчилж зурав.
3	Явган хүний замын ажлын тоо хэмжээг *өнгөт хавтангаар тооцож "Ажлын тоо* хэмээ"-д тусгах	Явган хүний замын ажлын тоо хэмжээг өнгөт *хавтангаар тооцож "Ажлын тоо хэмээ"-д тусгав.*
4	Трасс-1 ийн хамгийн их дагуу налуу норм стандартад заагдсанаар дахин төлөвлөх.	Төлөвлөж буй авто замыг "Хот суурины гудамж, зам төсөллөх" БНБД 32-01-04-д 8% гэж заасны дагуу төлөвлөсөн болно.
5	Трасс-2-ийн авто замыг "Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам "-ийн зурвасын эгнээний тоо 2, нэг зурвасын өргөн 3.0м гэсэн заалтын дагуу төлөвлөх.	Авто замын зураг төслийг Захиалагчтай зөвшилцөх явцад хувийн эзэмшлийн объект болон хашаа дайрсан. Тус хэсэгт Захиалагчаас газар чөлөөлөх боломжгүй тухай мэдэгдсэн тул хөдөлгөөний зурвасыг 1 чиглэлд зорчихоор төлөвлөв.
6	Нэг маягийн хөндлөн огтлолыг дахин зурах	Нэг маягийн хөндлөн огтлолыг дахин зурав.
7	Хашлага хэвтүүлж гарц гаргах хэсгийг шинээр зурах	Хашлага хэвтүүлж гарц гаргах хэсгийг шинээр зурав.
8	Ус сувгийн удирдах газар болон цахилгаан,холбоо дулааны холбогдох мэргэжлийн байгууллагуудаас техникийн нөхцөл авах, хэрэв авах шаардлагагүй бол тэр тухайгаа тайлбар бичигт тусгах.	Ус суваг болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцөж холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зуруулав.
9	Инженер геодезийн зураглалын тайлангийн "геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэрэг №1, №2, №3"-д гарын үсэг зуруулж баталгаажуулах.	Инженер геодезийн зураглалын тайлангийн "геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэрэг №1, №2, №3"-д гарын үсэг зуруулж баталгаажуулав.
10	Нарийвчилсан зургийн булангийн хүснэгтэд бичигдэх хуудасны дугаарыг дахин хянаж,засварлах	Булангийн хүснэгтийг хянаж засварлав.

Дүгнэлт бичиж,биелэлтийг шалгасан эксперт № ..... Ч.Баясгалан

MONGOLIA
33И-22/005
CONSULTING ENGINEER
BAYASGALAN
Choijiljav

2025 оны 5-р сарын 07-ны өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн инженер ..... Б.Түвшинтөгс

2025 он 5 сар 07-ны өдөр

Эксперт дүгнэлтийг компьютерээр 3 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

- Ажлын зураг (Зургийн шифр 24/22) 87 хуудас А3
- Тайлбар бичиг (Зургийн шифр 24/22) 46 хуудас А4
- Техникийн шаардлага (Зургийн шифр 24/22) 206 хуудас А4
- Инженер геодезийн тайлан 23 хуудас А4
- Инженер геологийн судалгааны дүгнэлт 15 хуудас А4, 7 хуудас А3

д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,13-р хороо, 7-р хэсгийн гэр хороолол дундах авто замын зураг төсөл
2	Обьектын байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,13-р хорооны нутаг дэвсгэрт Авто замын урт 1.4 км
3	Зураг төслийн байгууллага	"Ихэр мөнх" ХХК
4	Зургийн инженер	Б.Түвшинтөгс, Ц.Ууганбат
5	Захиалагч	Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн ЗДТГ
3.Дүгнэлтийн товч утга.		
/Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалын 9 дүгээр зүйлээс/		Дүгнэсэн нь:
1	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	1. Ажлын даалгавар • Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгийн газрын дарга С.Энхбаярын 2024 оны 6 сарын 6-ний өдөр баталсан "Хан-Уул дүүргийн 13-р хороо, 7 хэсгийн гэр хороолол дундах авто замын зургийн даалгавар". Зургийн даалгавар дугааргүй. • Нийслэлийн ерөнхий архитектор Г.Батзоригийн 2024 оны 7 дугаар сарын 26-ний өдөр баталсан 2024/00-426 дугаартай "Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар" 2. Авто замын байршил, техникийн нөхцлийн талаар дараах байгууллагатай зөвшилцсөн байна. • Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Буянт, • Нийслэлийн замын хөгжлийн газрын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга В.Мягмар • Нийслэлийн замын хөгжлийн газрын бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн И.Номингэрэл • Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мөнхбаатар, • Геодези, усны барилга байгууламжийн ерөнхий инженер С.Батсайхан 3. Авто замын байршил, техникийн шийдлийг баталсан байдал • Нийслэлийн ерөнхий архитектор Ч.Төгсгэрэл баталсан. • Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандарын газрын Ерөнхий архитекторын ажлын алба 2025 оны 2 дугаар сарын 24-ний өдөр тэмдэг дарж баталгаажуулсан. Ингэхдээ ХБХСГ-ын 2024 оны 7 дугаар сарын 26-ний өдөр баталсан 2024/00-428 дугаартай авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврын дагуу гүйцэтгэсэн" гэж тэмдэглэсэн.

		• Хот байгуулалт, хотын стандартын газрын хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч Ц.Лхамсүрэн, Хот байгуулалт, хотын стандартын газрын замын хөдөлгөөн, төлөвлөлт хариуцсан инженер Б.Дулмаа нар хянасан байна.
2	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	• Авто замын зургийн шифр нарийвчилсан зургийн нүүр хуудсанд 24/23, тайлбар бичиг, нарийвчилсан зургийн хүснэгтэд 24/22 байгаа нь ойлгомжгүй байна. • Автозамын зорчих хэсгийн нэг зурвасын өргөн 3.0 м, явган замын өргөн 1.5 м-ээр төлөвлөсөн нь "Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам" зэрэглэлд хамрагдаж байна. Тайлбар бичигт "Туслах гудамж зам, II зэрэглэлийн зам" гэж тодорхойлсон байна. • Явган хүний замыг асфальт бетон хучлагатай төлөвлөсөн боловч Тайлбар бичгийн 13-р зурагт "Өнгөт хавтан"-аар хийнэ гэж үзүүлсэн, дэвсгэр зураг дээр хавтан гэж тэмдэглэсэн нь зөрүүтэй байна. • Ажлын зурагт "Авто замын хашлагыг хэвтүүлж гарц гаргах хэсгүүдэд М250 бетоноор хийнэ" гэсэн тайлбартай зураг байгаа бөгөөд бетоны зузаан болон хэмжээг гаргаагүй, бетоны ажлыг "Ажлын тоо хэмжээ"-д тусгаагүй байна. Бетон гарцны өргөн тусгайлсан зурагт 8 м, дэвсгэр зурагт 9 м байгаа нь зөрүүтэй байна. Энэ зургийн План проекц, Харагдах байдал гэсэн зургууд зөрүүтэй. Нүүрний проекц, тайлбар хоёр хоорондоо зөрүүтэй. Масштаб алдаатай. • Нийслэлийн замын хөгжлийн газраас "Зөвхөн дэвсгэр зургийг зөвшилцлөө. Нарийвчилсан зургийг дахин хянана" гэсэн тайлбарыг өгсөн байна. Дахин хянасан талаар тайлбар байхгүй байна. • Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын өгсөн зөвлөмжийн дагуу тооцоо хийж, гадаргуун ус зайлуулалтыг төлөвлөх, ус зайлуулалтын ерөнхий схем, дагуу зурах • Замын үндсэн трассд байрлуулсан 500 мм ган төмөр хоолойгоор гарах усны тооцоо байхгүй. • Сургууль орчмын автозамд хүүхдийг авто замын хөдөлгөөнөөс сэргийлэх тэмдэг тэмдэглэгээг нэмж хийх • Ажлын даалгаварт холбогдох мэргэжлийн байгууллагууд, инженерийн шугам сүлжээ хариуцсан байгууллагуудаас техникийн нөхцөл авч, зөвшилцөх талаар тусгасан болвч Хан-Уул дүүргийн ЗДТГ, НЗХГ, ХБХСГ, ГУББГ зэрэг байгууллагуултай зөвшилцсөн байна. • Инженер геодезийн хэмжилтийн ажлыг "Эй Эс системс" ХХК гүйцэтгэж зураглалын тайлан ирүүлсэн байна. Инженер. Г.Золбаяр. Зөвлөх инженер Ш.Ганболд • Инженер геологийн судалгааны ажлыг "Лэнд тест" ХХК гүйцэтгэж дүгнэлт ирүүлсэн. Инженер Д.Баяржаргал, Захирал И.Сайнсанаа
3	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	• Инженер геодезийн зураглалын тайлангийн "Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэрэг №1, №2," нь гарын үсэг зурагдаагүй, баталгаагүй. • Инженер геологийн судалгааны дүгнэлт Улсын магадлалаар 2024 оны 9 сарын 12-д баталгаажсан.
4	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	• Зам барилгын ажлын ерөнхий техникийн шаардлага, зураг төслийн тайлбар бичигт тусгасан. •
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/	

1	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	•
2	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	•
3	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	•
4	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч замтөлөвлөсөн. •
